



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/490

Мөрөн сум

Урамшуулал, дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "в", 29.1.6-гийн "г", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Төсвийн тухай хуулийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжилт бус XI хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Уртрагийн давааны зам, засвар арчилгааны ажилд идэвхтэй сайн ажилласан иргэн Х.Ган-Очир, П.Ганзориг, С.Цэрэнсүрэн нарт тус бүрт нь 200.000 (Хоёр зуун мянга), Р.Өлзийбаатар, Б.Болдбаатар, Г.Эрдэнэзаяа, М.Ганзориг, Б.Баатар, Л.Ганбат, Д.Бат, Х.Цэнгэл, Г.Золзаяа, Ч.Оюундарь, Ж.Цэрэндорж, нарт тус бүрт нь 100.000 (Зуун мянга) төгрөгийн урамшуулал дэмжлэг, Цагаан-нуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 100000 (Нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх 2700000 (Хоёр сая долоон зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсвийн Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлж, амьдрах орчныг сайжруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир) -д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД